



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/185

Бат-Өлзий сум

Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дах хэсэг, Засгийн газрын “Журам батлах тухай” 2017 оны 144 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Б.Ганням (Эрүүл мэндийн төвийн даргын түр орлон гүйцэтгэгч)

Г.Баттулга (Соёлын төвийн даргын түр орлон гүйцэтгэгч)

Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Д.Доржханд (Нийгмийн бодлогын мэргэжилтний ажлыг түр орлон гүйцэтгэгч)

Б.Ууганцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

Г.Сарантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын нэгжийн багш-арга зүйч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Сумын цэрэг татлагын ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Цэргийн жинхэнэ албанд татагдаж буй иргэдэд эрүүл мэндийн үзлэг явуулах эмч, мэргэжилтнүүдийг ажиллуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн байлгах, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, Эрүүл мэндийн төвөөс мэргэжлийн албан тушаалтнуудыг томилж ажиллуулахыг Эрүүл мэндийн төвийн даргын түр орлон гүйцэтгэгч, их эмч (Б.Ганням)-д, цэрэг татлага явуулах байр бэлтгэхийг

627301389

Соёлын төвийн даргын үүрэг гүйцэтгэгч (Г.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай..

4. Цэрэг татлагын үеэр нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч (Д.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2023 оны 09
дүгээр сарын 18-ны өдрийн
А/1.25 дугаар захирамжийн хавсралт

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Ажлын хуваарь танилцуулсан байдал
1	2	3	4	5
1.	Цэрэг татлагын ажлын хэсэг хуралдах	9 сарын 26	ЗДТГ-ын дарга	
2.	Цэрэг татлагын комиссын ажиллагаанд шаардагдах хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулан шийдвэрлэсэн байна	09 сарын 25	ЗДТГ-ын дарга	
3.	Эрүүл мэндийн төв, багийн эмч нартайгаа хамтран эрүүлжүүлэх боломжтой 18-25 насны залуучуудыг цэрэг татлагаас өмнө эмчийн үзлэгт хамруулан суманд эмчлэх боломжтойг нь эмчлэн эрүүлжүүлж, цэргийн албанд тэнцүүлэх арга хэмжээг авна.	10 сарын 01-ны дотор	ЭМТөвийн дарга Б.Ганням БЗДарга нар	
4.	Цэрэг татлагын комиссын бэлтгэл ажлыг хэрхэн хангаж ажилласан талаарх танилцуулга сонсох 5-10 минутын хугацаатай Power Pont программ дээр бэлтгэж хийнэ	10 сарын 02	Ц.Баасанжав Д.Доржханд	
5.	“Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын 2.2.1-д заасны дагуу цэрэг татлагын комиссоор ороод тэнцсэн иргэнийг шинжилгээнд хамруулан шинжилгээний хариуны хамт анги байгууллагад нь хүлээлгэн өгнө. 8 төрлийн шинжилгээ өгнө. Үүний боломжтойг нь суманд, боломжгүйг нь аймгийн БОЭТөвийн шинжилгээний лабораторт нэгдсэн байдлаар өгнө	10 сарын 02-03	ЗДТГ-ын дарга	
6.	Сумын ЭМТөвтэй хамтран цэргийн насны залуучуудын эрүүлсэн тайланг үнэн зөв, бодитой гаргаж өмнөх оныхтой харьцуулсан судалгаа өвчлөл тус бүр дээр өссөн, буурсан үзүүлэлттэйгээр нарийвчлан гаргах.	10 сарын 02-ны дотор	ЗДТГ-ын дарга ЭМТөв	
7.	Цэрэг татлагын комисст ажиллаж байгаа бүрэлдэхүүнийг амны хаалт, нэг удаагийн бээлий, гар ариутгагчаар хангах.	10 сарын 03	ЭМТөв,	

8.	Цэрэг татлагын байранд нэг дор 20-оос дээш цэрэг татагдагч иргэн цуглуулахгүйгээр цагийн нарийвчлалтайгаар цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.	10 сарын 03	Д.Энх-Амгалан Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч НТБ-ын багш-арга зүйч	
9.	Цэрэгт татагдагчдын нэрсийн бүртгэлийг 18-25 насны болон 1998-2005 онд төрсөн иргэдийн овог нэр, регистрийн дугаарыг Цэргийн штабаас Excel программ дээр боловсруулсан үйлдлийн системийн дагуу нэг бүрчлэн бичиж оруулан бэлэн болгон томъёожуулсан байна.	10 сарын 03	Багийн Засаг дарга нар БХЭрхлэгч	
10.	Зарлан дуудах мэдэгдлийг цэрэгт татагдагч иргэн бүрт гардуулан өгч, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулж, буцаах тасалбараар Тамгын газрын даргатай тооцоо хийсэн байх.	10 сарын 02	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар	
11.	Иргэний үнэмлэх аваагүй иргэдийг үнэмлэхжүүлэх	10 сарын 09-ны дотор	Улсын бүртгэгч Ө.Гөлгөө	
12.	Цэрэгт татагдагч иргэн бүр иргэний үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, ЭМ-ийн картаа заавал авч ирсэн байх, ар гэрийн гачигдлын учир чөлөөлүүлэхийг хүссэн иргэд багийн Засаг даргын тодорхойлолт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, сумын цэрэг татлагын товчоогоор нэг бүрчлэн хэлэлцүүлж зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.	10 сарын 03-ны дотор	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар Нийгмийн даатгалы н байцаагч Улсын бүртгэгч	
13.	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг дулаан, гэрэлтүүлэг сайтай байлгах, хивс дроз дэвссэн, агааржуулалтын шаардлага ханган, ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангах.	10 сарын 03	Г.Баттулга Б.Ганням Г.Бүд М.Бат-Өлзий	
14.	Цэрэгт татагдагчдын анкетыг шинэчлэгдсэн загвараар нээж 2 хувь үнэн зөв компьютерээр бичиж, зураг наан, ам бүлийн талаар шинэчлэн тодотгож дэлгэрэнгүй бичих	10 сарын 08-ны дотор	Багийн Засаг дарга нар	
15.	Цэрэг татлагаар их, дээд сургуулиудын нэгдүгээр дамжаа буюу шинэ оюутнуудыг дуудахгүйгээр бусад дамжааны оюутан сурагчдыг "Цэргийн албаны тухай" хуулийн дагуу цэрэг татлагад бүрэн хамруулах учир оюутан, сурагчид, цэрэг татлагад ирэхдээ сургуулийн тодорхойлолт, төлбөр төлсөн	10 сарын 03	Багийн Засаг дарга нар	

	баримтыг үндэслэн цэрэгт татах эсэх талаар шийдвэр гаргана.			
16.	Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоол, 2023 оны 119 дүгээр тогтоолуудын дагуу 1996, 1997 оны цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд зарлах дуудах мэдэгдэл өгч цэрэг татлагын өдрүүдэд бидэнтэй уулзуулахад бэлэн байлгах. Мөнгөн төлбөрийн тооцоотой иргэдийн өмнөх онуудын цэрэг татагдагчдын анкетийг оноор нь архивлан бэлтгэсэн байх.	10 сарын 08-ны дотор	Багийн Засаг дарга нар Г.Доржханд	
17.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийг холбогдох бичиг баримтын хамт бэлэн байлгах, ажлын үр дүнг хүн нэг бүрээр тооцох	10 сарын 03	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар	
18.	Цэрэг татлагын комиссоор орох бүх иргэдэд цэргийн үүрэгтний үнэмлэх бүрэн олгогдсон байх	10 сарын 03	ЗДТГ-ын дарга Ц.Баасанжав	
19.	Цэрэг татлагын комиссоор орох иргэдийг гэрээсээ углааштай ирэхийг анхааруулж, хөл нүцгэн үзлэгээр оруулахгүй байх.	10 сарын 03	Багийн Засаг дарга нар	
20.	Зарлан дуудах хуудастай хамт бөглөсөн мэдэгдэх хуудсыг бэлэн байлгах, 2023 онд 18-25 насны бүх иргэдэд зарлан дуудах мэдэгдэл хүргүүлэх /сараар 18 насанд хүрээгүй иргэнд зарлан дуудах хуудас хүргүүлээгүй гэсэн асуудал гаргахгүй байх/	10 сарын 03	Багийн Засаг дарга нар	
21.	Батлан хамгаалахын тухай хууль, Цэргийн албаны тухай хууль сурталчилсан мэдээлийн самбар бэлтгэн байршуулах.	10 сарын 03	Г.Доржханд Д.Доржханд	